



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 3 сарын 10 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Х ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын Х хурал 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06:00 цагаас Төрийн ордон дахь Монгол Улсын Шадар сайдын ажлын өрөөнд 88 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Монгол Улсад коронавируст (COVID-19) халдварын анхны батлагдсан тохиолдол Бүгд Найрамдах Франц Улсаас зөөвөрлөгдөн орж ирсэнтэй холбогдуулан үүссэн нөхцөл байдлын талаар Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэлийн мэдээллийг сонсов.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Монгол Улсад коронавируст халдвар (COVID-19)-ын анхны батлагдсан тохиолдол Бүгд Найрамдах Франц Улсаас зөөвөрлөгдөн орж ирсэн тул халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэл, аймаг, сумаас гарах хот хоорондын зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгсэл, орон нутгийн хуваарьт нислэг, суудлын галт тэрэгний хөдөлгөөнийг түр зогсоох арга хэмжээ авах;

2. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажилтай холбогдуулан улс төрийн намуудаас тавьсан саналыг хэлэлцэн, улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийг дуустал нийтийг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулахгүй байхыг Засгийн газрын 2020 оны 64 дүгээр тогтоолоор шийдвэрлэснийг мөрдөж ажиллахыг Сонгуулийн ерөнхий хороо, улс төрийн намуудад чиглэл болгохоор тус тус тогтов.

Нэг. Засгийн газрын хэвлэл мэдээлэл,
олон нийттэй харилцах хэлтсийн дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Ц.Ганзоригт:

1.1. Үүссэн нөхцөл байдлын талаар олон нийтэд мэдээллийн нэг сувгаар шуурхай мэдээлэх;

Хоёр. Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,
Тагнуулын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Д.Гэрэл,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал С.Баатаржав,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү,
Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин нарт:

2.1. Коронавируст халдвар (COVID-19)-аар өвчилсөн Франц Улсын иргэнтэй 1, 2 дугаар хавьталтай хүмүүсийг олж тогтоох, тусгаарлалт, хяналтад авах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

2.2. Коронавируст халдвар (COVID-19)-аар өвчилсөн Франц Улсын иргэний Монгол Улс дахь явсан маршрут, үйлчлүүлсэн зочид буудал, худалдаа, үйлчилгээ, нийтийн хоол, унаа, ажлын байрыг нарийвчлан тогтоож, холбогдох арга хэмжээг шуурхай авч ажиллах;


Гурав. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатарт:

3.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан коронавируст халдвар голомтлон гарсан улс орнуудаас Монгол Улсад ирж буй гадаадын иргэдийг халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор тусгаарлах байранд болон гэрээр тусгаарлах зөвлөмжийг Эрүүл мэндийн яамнаас өгч байгааг Монгол Улс дахь дипломат төлөөлөгчийн газар, олон улсын болон донор байгууллагуудын төлөөлөгчийн газруудад шуурхай мэдээлж, дээрх зөвлөмжийг чанд сахиж хэрэгжүүлэхийг анхааруулах;

Дөрөв. Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал С.Баатаржав,
аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

4.1. Улсын онцгой комиссын 2020 оны 5 дугаар тогтоол гарсантай холбогдуулан хот, аймаг, сум хоорондын хүнсний болон бусад ачаа тээвэрлэлтийг хэвийн явуулах, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас (ажлын зайлшгүй шаардлага, хойшлуулшгүй ажил, албан томилолт, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ, ар гэрийн гачигдал гэх мэт) хот хооронд зорчих төрийн албан хаагч, иргэдийг нотлох баримтыг үндэслэн хүндрэл чирэгдэл учруулахгүйгээр шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтрүүлэх арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг тус тус үүрэг болгов.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮВШИН

ХЯНАСАН:

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

A large, stylized signature in black ink, written over the text of the official.

Г.АРИУНБУЯН